



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/07

Хэрлэн сум

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд аймгийн Аудитын газраас хийсэн нийцлийн аудитаар мэдээллийг хангалтгүй байршуулсан, хугацаа хоцроосон зөрчил гаргасан аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Г.Энхбаярыг сонсох ажиллагааг хийх итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Л.Бат-Октябрь, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Э.Мөнх-Эрдэнэ нарыг томилсугай.

Хоёр. Сонсох ажиллагааг Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу хийж гарсан саналыг 2017 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн дотор танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Л.Бат-Октябрь, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Э.Мөнх-Эрдэнэ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 027